

ИРГЭНИЙ ШИЛЖИЛТ, ХӨДӨЛГӨӨН

УИХ-ын Сонгуулийн тухай хуульд заасны дагуу иргэний засаг захиргааны нэг нэгжээс нөгөө нэгжид шилжин суурьших хөдөлгөөнийг нөхөн сонгууль явуулах тухай эрх бүхий байгууллагын шийдвэр гарсан бол уг шийдвэрийг улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад **ирүүлсэн өдрийн дараах ажлын өдрөөс** эхлэн зогсоож, **санал авах өдрийн дараах өдрөөс буюу 2021 оны 10 дугаар сарын 11-ний өдрөөс сэргээнэ.**



Харин сонгуулийн байгууллагын ажилтан, итгэмжлэгдсэн ажилтан, мэдээллийн технологийн багийн гишүүн, даамал, санал авах байр болон сонгуулийн үйл ажиллагааны аюулгүй байдлыг хангахаар ажиллаж байгаа цагдаагийн албан хаагчийн сонгогчийн шилжилтийг хийх, бүртгэхдээ тухайн байгууллагынх нь албан бичгийг үндэслэн **санал авах өдрөөс 14-өөс доошгүй хоногийн өмнө буюу 2021 оны 9 дүгээр сарын 26-ны өдрөөс өмнө** шийдвэрлэнэ.

Түүнчлэн нэр дэвшигч болон энэ хуулийн 37.3-т заасан менежер, шадар туслагч нь сонгуулийн нэг хэсгээс нөгөө хэсэгт шилжих бол **2021 оны 9 дүгээр сарын 26-ны өдрөөс өмнө** сонгогчийн шилжилтийг хийлгэж болно. Эдгээр сонгогчид нь **2021 оны 9 дүгээр сарын 26-ны өдрөөс өмнө** сонгогчийн шилжилтийг бүртгүүлнэ.